



ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Дорнод аймгийн Боловсрол, соёл урлагийн газрын 2019 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ДОА-2020/86/СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Дорнод аймаг 2020 он	Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд Тэргүүлэх аудитор: Б.Болортуул Утас: 70584203 Цахим хаяг: Bolortuulb@audit.gov.mn Аудитын менежер: В.Цэнгэлмаа Утас: 70584204 Цахим хаяг: Tsengelmaav@audit.gov.mn Ахлах аудитор: Б.Дэлгэрмаа Утас: 70584207 Цахим хаяг: delgermaab@audit.gov.mn
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТШЗ	Төсвийн шууд захирагч
НББ	Нягтлан бодох бүртэл
ДОА	Дорнод аймаг



	Агуулга
Аудитын гэрчилгээ	3
Аудитын тайлан.....	5
2.1. Оршил	5
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	5
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	5
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	6
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	6
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	6
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	6
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	6
2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	7
2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	8
2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	9
2.13. Шилэн дансны мэдээлэл	9
2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	10
2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	11
Менежментийн захидал	102
Аудит хийгдсэн санхүүгийн тайлан	113
4.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан	114
4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	115
4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	136
4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	157
4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	158
4.6 Аудит хийгдсэн нэмэлт санхүүгийн тайлан.....	Error! Bookmark not defined.8



		БОЛОВСРОЛ, СОЁЛ УРЛАГИЙН ГАЗРЫН ДАРГА А.НАНСАЛМАА ТАНАА	
ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР			
21000, Дорнод аймаг, Хэрлэн сум 7-р баг ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203			
2020.02.11		№	27
танай	-ны №	-т	
Аудитын гэрчилгээ			
Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Боловсрол, соёл урлагийн газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.			
Зөрчилгүй санал дүгнэлт			
Боловсрол, соёл урлагийн газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн Сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.			
Санал дүгнэлтийн үндэслэл			
Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын Олон Улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.			
Аудитаар Боловсрол, соёл урлагийн газрын 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.			
Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай; зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.			
110519512			



Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн Сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БОЛОРТУУЛ



2.1. Оршил

Дорнод аймгийн Боловсрол, соёл урлагийн газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг газрын дарга А.Нансалмаа Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорнод аймгийн Боловсрол, соёл урлагийн газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дорнод аймгийн Боловсрол, соёл урлагийн газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 01 дүгээр сарын 27-ноос 2020 оны 02 дугаар сарын 03-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 02 дугаар сарын 07-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, ахлах аудитор Б.Дэлгэрмаа хариуцаж хэрэгжүүлэв.

Дорнод аймгийн Боловсрол, соёл урлагийн газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт 2020 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 32 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.



2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Дорнод аймгийн Боловсрол, соёл урлагийн газрын үйл ажиллагааны эрхэм зорилго нь "Иргэнийг оюун ухаан, ёс суртахуун, бие бялдын зохих чадавхтай, хүмүүнлэг ёсыг дээдлэн сахидаг, бие даан сурах, ажиллах, амьдрах чадвартай болгон төлөвшүүлэхэд оршино".

Үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Харьяа газруудад мэргэжлийн туслалцаа үзүүлэх, тэдгээрийг онол арга зүйн мэдээллээр хангах, зөвлөгөө өгөх, үр дүнд хяналт шинжилгээ хийх, гүйцэтгэлийг хянах.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус газрын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Дорнод аймгийн Боловсрол, соёл урлагийн газар нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд "Acolous" программ хангамж ашигладаг байна.

Дорнод аймгийн Боловсрол, соёл урлагийн газрын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд "дунд" гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Дорнод аймгийн Боловсрол, соёл урлагийн газрын бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 11 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг "дунд" гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 958,060.9 мянган төгрөгөөс тооцон 19,161.2 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.



Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 51,251.1 мянган төгрөгөөр тооцсон болно.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Дорнод аймгийн Боловсрол, соёл урлагийн газрын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 548.2 мянган төгрөгөөр буюу 4.4 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө			
Авлага	75,3	68,5	- 6,8
Урьдчилгаа			
Бараа материал	24271,0	14806,7	-9464,3
Үндсэн хөрөнгө	1496967,1	1501349,5	4382,4
Хуримтлагдсан элэгдэл	287098,0	336825,1	-49728,1
Нийт хөрөнгө	1252966,5	1198149,6	-54816,9
Өр төлбөр			
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1252966,5	1198140,6	-54816,9
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1252966,5	1198149,6	-54816,9

Авлага данс үлдэгдэлтэй байгаа нь өмнөх оны нийгмийн даатгалаас авах авлагыг суутган тооцсон ч тайлант онд тооцооллын алдаанаас шалтгаалж дахин авлага үүсгэсэн байна. Тооцоо нийлсэн актаар баталгаажсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл буурсан нь 9.4 сая төгрөгийн бараа материалыг акталсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө өмнөх оноос өссөн нь БСШУЯ-наас 4.4 сая төгрөгийн хөрөнгийг шилжүүлэн авснаас шалтгаалсан байна.

Засгийн газрын оролцоо буурсан нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Орлого бүрдүүлдэг байгууллага биш тул орлогын төлөвлөгөө тусгагдаагүй байна.

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх үндсэн үйл ажиллагаанд зориулан 1,818,720.8 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 1,818,720.8 мянган төгрөгийг урсгал зардалд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 1,818,720.8 мянган төгрөгийг улсын төсвөөс төлөвлөжээ.

Нийт зардлын гүйцэтгэл 97.3 хувьтай байна



Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Нэмэлт төсөв: БСШУЯ-аас 589,987.5 мянган төгрөг, аймгийн ЗДТГ-аас 96,430.6 мянган төгрөг нийт 686'417,5 мянган төгрөгийн санхүүжилтийг олгож 100.0 хувь зарцуулсан байна.

2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 11 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 11 эрсдэл тодорхойлж нийт 11 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 69,097.3 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 1,118.9 мянган төгрөгийн зөрчилд 1 акт тогтоож, 65150,9 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлж, 2,827.5 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 зөвлөмж, хариуцлага тооцуулах 1 саналыг тус тус өглөө.

Аудитаар дараах 69097,3 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрснээс 66269,8 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, албан шаардлага хүргүүллээ. Үүнд:

1. Татварын цахим e-barimt.mn сайтаар худалдан авалтыг тулган баталгаажуулахад 1,118,927.0 төгрөгийг хувийн хэрэглээний бараа материалыг төсвөөс худалдан авч, бараа материалын тайланд тусгалгүйгээр шууд зардлаар бүртгэсэн нь Төсвийн тухай хуулийн 16.5.5 дахь “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэсэн заалтыг зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн эрх ба үүрэг, иж бүрэн байдал, хэмжилт, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоох.

2. Нийт худалдан авалтын 88.3 хувь буюу 65,1 сая төгрөг нь татварын нэгдсэн цахим хуудас дахь Е-баримтад бүртгэгдээгүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3.1.3 дахь “анхан шатны баримт гэж, төлбөр төлсөн баримт болон бусад нотолгоог”, 13.4 дэх “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна”, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар батлагдсан “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягыг нөхөх заавар”-ын 6.5 дахь Монгол Улсын стандарт MNS 6529:2015 “татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага”-тай тус тус нийцэхгүй байгаа бөгөөд санхүүгийн тайлангийн үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөх.

3. Төсвөөс байгууллагын үйл ажиллагаанд хамааралгүй бараа материал худалдан авч төсвийн зардлаар тайлагнасан нь анхан шатны баримтаас зөрүүтэй байгаа нь дотоод хяналт хангалтгүй байгаатай холбоотой байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1. дэх “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.” гэсэн заалтад нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Холбогдох ажилтнуудад хариуцлага тооцох санал хүргүүлэх.

Аудитаар илэрсэн 2,827.5 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 2 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.



2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Байхгүй.

2.12. Шилэн дансны мэдээлэл

Дорнод аймгийн Боловсрол, соёл урлагийн газрын Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 8 мэдээллийг хугацаанд нь, 1 мэдээллийг байршуулаагүй байна.

2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 1,539,388.2 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлснийг хэрэгжүүлсэн байна.

Нийт 1 зөвлөмж өгснийг хэрэгжүүлсэн байна.

2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Дорнод аймгийн Боловсрол, соёл урлагийн газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Дорнод аймгийн Боловсрол, соёл урлагийн газрын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4.1.3, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.



Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын **агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс** урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Балансын данстай холбоотой асуудал

- 1.1. **Илрүүлэлт:** Нийгмийн даатгалын шимтгэлд 68,5 мянган төгрөгийг илүү тооцон шилжүүлж авлага үүсгэсэн байна.
- 1.2. **Эрсдэл:** Төсвийн зарцуулалтын үр ашиг буурах.
- 1.3. **Өгсөн зөвлөмж:** Төсвийн тухай хуулийн 16.5.5 дахь заалтад “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, 41.2.3 дахь заалтад “төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах;гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллах.
- 1.4. **Байгууллагаас өгсөн хариу тайлбар:** Хэрэгжүүлж ажиллана.

2. МУЕА-аас өгсөн чиглэл

- 2.1. **Илрүүлэлт:** Шатахууны зарцуулалтын тооцооны анхан шатны баримтад жолоочийн тооцооны хуудсыг бүрэн хөтлөөгүй, ирсэн явсан хугацаа байхгүй, спидометрийн заалт бичээгүй, тооцоог бүрэн бодоогүй байна.
- 2.2. **Эрсдэл:** Төсвийн хөрөнгө арвилан хэмнэлтгүй зарцуулагдах.
- 2.3. **Өгсөн зөвлөмж:** Төсвийн тухай хуулийн 6.4.1 дэх “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 13.7 дахь “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэсэн заалтуудыг хэрэгжүүлж ажиллах.
- 2.4. **Байгууллагаас өгсөн хариу тайлбар:** Хэрэгжүүлж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.



Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Аудит хийгдсэн санхүүгийн тайлан

4.1. Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	24 346 316,37	14 875 191,48
33	АВЛАГА	75 292,02	68 504,48
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	75 292,02	68 504,48
35	БАРАА МАТЕРИАЛ	24 271 024,35	14 806 687,00
354	Хангамжийн материал	24 271 024,35	14 806 687,00
35410	Бичиг хэргийн материал	379 792,00	24 475,00
35420	Аж ахуйн материал	1 860 640,00	1 544 200,00
35470	Бусад хангамжийн материал	22 030 592,35	13 238 012,00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1 228 620 215,62	1 183 274 446,96
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1 228 620 215,62	1 183 274 446,96
392	Биет хөрөнгө	1 211 495 215,62	1 166 899 446,96
39201	Барилга, байгууламж, орон сууц	1 200 648 804,00	1 200 648 804,00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-61 700 007,86	-81 710 821,22
39203	Авто-тээврийн хэрэгсэл	51 000 000,00	51 000 000,00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-32 777 777,53	-38 361 111,07
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	214 477 431,93	218 859 784,93
39206	Хуримтлагдсан элэгдэл	-168 302 039,38	-189 727 685,18
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	30 840 972,00	30 840 972,00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-22 692 167,54	-24 650 496,50
393	Биет бус хөрөнгө	17 125 000,00	16 375 000,00
39301	Програм хангамж	3 750 000,00	3 750 000,00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-1 625 000,00	-2 375 000,00
39303	Бусад биет бус хөрөнгө	15 000 000,00	15 000 000,00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1 252 966 531,99	1 198 149 638,44
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1 252 966 531,99	1 198 149 638,44
51	Засгийн газрын хувь оролцоо	1 252 966 531,99	1 198 149 638,44
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	208 593 243,20	208 593 243,20
51101	Өмч: - төрийн	208 593 243,20	208 593 243,20
512	Хуримтлагдсан үр дүн	1 039 812 733,27	984 995 839,72
51210	Өмнөх үеийн үр дүн	1 039 812 733,27	1 039 812 733,27
51220	Тайлант үеийн үр дүн	00,00	-54 816 893,55
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	4 560 555,52	4 560 555,52
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1 252 966 531,99	1 198 149 638,44

4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
------------	----------	---------------------	-----------------------



Дорнод аймгийн Боловсрол, соёл урлагийн газрын 2019 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	915 043 664,01	2 507 740 857,45
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1 403 820,00	2 602 553,00
120	Нийтлэг татварын бус орлого	00,00	2 602 553,00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	00,00	2 602 553,00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	00,00	2 602 553,00
	Хөрөнгийн орлого	1 403 820,00	
	Төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй хөрөнгө		
121001	борлуулсны орлого	1403820,00	
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	913 639 844,01	2 505 138 304,45
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	287 597 600,00	1 818 720 800,00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	287 597 600,00	1 818 720 800,00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	626 042 244,01	686 417 504,45
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	29 835 742,00	
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	211 202 010,00	96 430 600,00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	359 918 492,01	554 373 904,45
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	25 086 000,00	35 613 000,00
134003	Нийгмийн даатгалын сангаас эмнэлгүүдэд олгох санхүүжилт	00,00	00,00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	958 060 893,46	2 562 557 751,00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	958 060 893,46	2 562 557 751,00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	950 627 802,12	1 059 495 451,00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	216 903 400,00	248 208 400,00
210101	Үндсэн цалин	124 972 200,00	180 216 700,00
210102	Нэмэгдэл	36 446 100,00	50 997 781,00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	11 616 000,00	12 601 319,00
210104	Урамшуулал	00,00	4 392 600,00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	25 953 107,98	28 697 887,54
210201	Тэтгэврийн даатгал	17 714 007,98	19 516 687,54
210202	Тэтгэмжийн даатгал	2 059 700,00	2 295 300,00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1 647 800,00	1 836 200,00
210204	Ажилгүйдлийн даатгал	412 000,00	459 100,00
210205	Эрүүл мэндийн даатгал	4 119 600,00	4 590 600,00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	7 075 645,00	8 641 500,00
210301	Гэрэл, цахилгаан	3 234 094,00	3 520 259,00
210302	Түлш, халаалт	2 912 420,00	3 525 250,00
210303	Цэвэр, бохир ус	929 131,00	1 595 991,00
2104	Хангамж, бараа материалын зардал	5 440 000,00	18 482 897,35
210401	Бичиг хэрэг	639 170,00	1 852 313,00
210402	Тээвэр, шатахуун	1 703 070,00	2 334 296,00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2 730 274,00	2 934 336,00



210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	367 486,00	1 881 940,00
210408	Бараа материал акталсны зардал	00,00	9 480 012,35
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1 728 800,00	2 000 000,00
210604	Урсгал засвар	1 728 800,00	2 000 000,00
2107	Томилолт, зочны зардал	2 600 000,00	2 759 600,00
210702	Дотоод албан томилолт	2 600 000,00	2 759 600,00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	273 417 010,67	80 273 944,45
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	272 917 900,67	80 273 944,45
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	417 509 838,47	670 431 221,66
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	500 000,00	61 660 450,00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	360 154 297,00	559 042 650,00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	56 855 541,47	49 728 121,66
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	7 433 091,34	1 503 062 300,00
2132	Бусад урсгал шилжүүлэг	00,00	1 453 740 678,00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	00,00	620 919 684,00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	00,00	832 820 994,00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	7 433 091,34	49 321 622,00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	7 433 091,34	49 321 622,00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-43 017 229,45	-54 816 893,55
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-43 017 229,45	-54 816 893,55

4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	913 639 844,01	2 505 138 304,45
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	913 639 844,01	2 505 138 304,45
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	287 597 600,00	1 818 720 800,00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	287 597 600,00	1 818 720 800,00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	626 042 244,01	686 417 504,45
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив тусламж	29 835 742,00	-
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	211 202 010,00	96 430 600,00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	359 918 492,01	554 373 904,45



131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	25 086 000,00	35 613 000,00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	901 159 844,01	2 505 138 304,45
21	УРСГАЛ ЗАРДАЛ	901 159 844,01	2 505 138 304,45
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	893 726 752,67	1 002 076 004,45
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	216 903 400,00	248 208 400,00
210101	Үндсэн цалин	124 972 200,00	180 216 700,00
210102	Нэмэгдэл	36 446 100,00	50 997 781,00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	11 616 000,00	12 601 319,00
210104	Урамшуулал	00,00	4 392 600,00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	26 028 400,00	28 691 100,00
210201	Тэтгэврийн даатгал	17 789 300,00	19 509 900,00
210202	Тэтгэмжийн даатгал	2 059 700,00	2 295 300,00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1 647 800,00	1 836 200,00
210204	Ажилгүйдлийн даатгал	412 000,00	459 100,00
210205	Эрүүл мэндийн даатгал	4 119 600,00	4 590 600,00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	7 075 645,00	8 641 500,00
210301	Гэрэл, цахилгаан	3 234 094,00	3 520 259,00
210302	Түлш, халаалт	2 912 420,00	3 525 250,00
210303	Цэвэр, бохир ус	929 131,00	1 595 991,00
2104	Хангамж, бараа материалын зардал	5 440 000,00	9 017 500,00
210401	Бичиг хэрэг	639 170,00	1 867 988,00
210402	Тээвэр, шатахуун	1 703 070,00	2 333 236,00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2 730 274,00	2 934 336,00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	367 486,00	1 881 940,00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2 000 000,00	2 000 000,00
210604	Урсгал засвар	2 000 000,00	2 000 000,00
2107	Томилолт, зочны зардал	2 600 000,00	2 600 000,00
210702	Дотоод албан томилолт	2 600 000,00	2 600 000,00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	275 867 010,67	80 273 944,45
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	275 367 900,67	80 273 944,45
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	499 110,00	
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	357 812 297,00	622 643 560,00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	500 000,00	61 660 450,00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	357 312 297,00	560 983 110,00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	7 433 091,34	1 503 062 300,00
2132	Бусад урсгал шилжүүлэг	00,00	1 453 740 678,00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	00,00	620 919 684,00



213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	00,00	832 820 994,00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	7 433 091,34	49 321 622,00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	7 433 091,34	49 321 622,00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	12 480 000,00	00,00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	12 480 000,00	00,00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	12 480 000,00	00,00
2200	Дотоод эх үүсвэрээр	12 480 000,00	00,00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	12 480 000,00	00,00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-12 480 000,00	00,00
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	00,00	00,00
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	00,00	00,00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00,00	00,00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00,00	00,00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00,00	00,00

4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	193 593 243,20	4 560 555,52	1 082 829 962,72	1 280 983 761,44
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00,00	00,00	00,00	00,00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	00,00	00,00	00,00	00,00
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00,00	00,00	00,00	00,00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00,00	00,00	00,00	00,00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00,00	00,00	00,00	00,00
C07	Тайлант үеийн үр дүн	15 000 000,00	00,00	-43 017 229,45	-28 017 229,45



C08	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	208 593 243,20	4 560 555,52	1 039 812 733,27	1 252 966 531,99
D01	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	208 593 243,20	4 560 555,52	1 039 812 733,27	1 252 966 531,99
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00,00	00,00	00,00	00,00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	208 593 243,20	4 560 555,52	1 039 812 733,27	1 252 966 531,99
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00,00	00,00	00,00	00,00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00,00	00,00	00,00	00,00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00,00	00,00	00,00	00,00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00,00	00,00	00,00	00,00
D08	Тайлант үеийн үр дүн	00,00	00,00	-54 816 893,55	-54 816 893,55
D09	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	208 593 243,20	4 560 555,52	984 995 839,72	1 198 149 638,44

4.5.Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1 818 720 800,00	1 818 720 800,00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	315 658 500,00	315 658 500,00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	248 208 400,00	248 208 400,00
210101	Үндсэн цалин	180 216 700,00	180 216 700,00
210102	Нэмэгдэл	51 983 100,00	50 997 781,00
15000000	0,0	-43 017 229,45	-28 017 229,45
210104	Урамшуулал	4 392 600,00	4 392 600,00
210105	Гэрээт ажлын хөлс	00,00	00,00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	28 691 100,00	28 691 100,00
210201	Тэтгэврийн даатгал	19 509 900,00	19 509 900,00
210202	Тэтгэмжийн даатгал	2 295 300,00	2 295 300,00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1 836 200,00	1 836 200,00
210204	Ажилгүйдлийн даатгал	459 100,00	459 100,00
210205	Эрүүл мэндийн даатгал	4 590 600,00	4 590 600,00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	8 641 500,00	8 641 500,00
210301	Гэрэл, цахилгаан	3 855 000,00	3 520 259,00



210302	Түлш, халаалт	3 554 500,00	3 525 250,00
210303	Цэвэр, бохир ус	1 232 000,00	1 595 991,00
210304	Байрны түрээс	00,00	00,00
2104	Хангамж, бараа материалын зардал	9 017 500,00	9 017 500,00
210401	Бичиг хэрэг	300 000,00	1 867 988,00
210402	Тээвэр, шатахуун	4 088 800,00	2 333 236,00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	840 000,00	2 934 336,00
210404	Ном, хэвлэл	300 000,00	00,00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	500 000,00	00,00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2 988 700,00	1 881 940,00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	00,00	00,00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2 000 000,00	2 000 000,00
210604	Урсгал засвар	2 000 000,00	2 000 000,00
2107	Томилолт, зочны зардал	2 600 000,00	2 600 000,00
210702	Дотоод албан томилолт	2 600 000,00	2 600 000,00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3 000 000,00	3 000 000,00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3 000 000,00	3 000 000,00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	13500000,00	13500000,00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	500 000,00	500 000,00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	13 000 000,00	13 000 000,00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1503062300,00	1453740678,00
2132	Бусад урсгал шилжүүлэг	1 503 062 300,00	1 453 740 678,00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	669 196 700,00	620 919 684,00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	833 865 600,00	832 820 994,00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	7 433 091,34	49 321 622,00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	7 433 091,34	49 321 622,00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1 818 720 800,00	1 818 720 800,00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1 818 720 800,00	1 818 720 800,00
131001	Улсын төсвөөс санхүүжих	1 818 720 800,00	1 818 720 800,00
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	22,00	22,00
650001	Терийн захиргааны албан хаагч (ТЗ)	15,00	15,00
650009	Терийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	07,00	07,00

4.6 Аудит хийгдсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		686 417 504,45
21	УРСГАЛ ЗАРДАЛ		686 417 504,45



210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		686 417 504,45
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		77 273 944,45
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		77 273 944,45
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	0,00	609143560,00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		61 160 450,00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		547 983 110,00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	0,00	686 417 504,45
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		686 417 504,45
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		96 430 600,00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		554 373 904,45
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		35 613 000,00
131106	Төсвийн урамшуулал		00,00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)		